

# ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙ БОЛОН МОНГОЛ УЛСАД ОЛГОГДСОН ЭРХ

1

Далайн тээврийн салбарын шинжлэх ухааны магистр

Д.Байгалмаа

# АГУУЛГА

1. Монгол Улсын Далайн тээврийн салбарын өнөөгийн байдал
2. Монгол Улсын нэгдэж орсон Олон Улсын гэрээ, конвенцууд
3. Хөрш орнуудтай байгуулсан Засгийн Газар хоорондын хэлэлцээр
4. Далайн эрх зүйн тухай НҮБ-ын конвенц ба далайд гарцгүй орнуудад олгогдсон эрх
5. Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын Худалдаа хөнгөвчлөх хэлэлцээр

МОНГОЛ УЛСЫН ЗАМ,  
ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ



ДАЛАЙН ЗАХИРГАА

Хөлөг онгоцны  
бүртгэл

Далайн боомт  
ашиглалт

Далайн тээвэр

Дотоодын усан  
замын тээвэр

Үндэсний  
боловсон хүчин  
бэлтгэх



4

“Далайд гарцгүй орны  
транзит худалдааны  
тухай” 1965 оны  
Конвенци

“Далайд гарцгүй  
улсуудын далбаагаа  
мандуулах эрхийг  
хүлээн зөвшөөрөх  
тухай” 1921 оны  
Барселоны тунхаглал

Далайн эрх зүйн  
тухай” НҮБ-ын  
Конвенци-1982  
он

Дэлхийн  
Худалдааны  
Байгууллагын  
“Худалдаа  
хөнгөвчлөх  
хэлэлцээр”-2014



1966.05.11

БНМАУ-ын Ардын Их  
Хурлын Тэргүүлэгчдийн  
зарлигаар нэгдэн орсон.

1976.10.15

БНМАУ-ын Ардын Их  
Хурлын Тэргүүлэгчдийн  
зарлигаар нэгдэн орсон.

1996 онд УИХ-аар  
соёрхон баталж  
Монгол Улс нэгдэн  
орсон.


2017 онд УИХ-аар  
соёрхон баталж  
Монгол Улс нэгдэн  
орсон.

Энэхүү тунхаглал, конвенцид нэгдэн орсон явдал нь Монгол Улс далайн баялаг ашиглах, Олон Улсын худалдааны далайн тээврийн үйл ажиллагааг эхлүүлэх эрх зүйн орчны үндэс суурь болсон юм.


# ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ГЭРЭЭ, КОНВЕНЦИ

5


№	МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИЙН ЖАГСААЛТ	Нэгдэн орсон огноо
1	Далайд гарцгүй улсуудын далбаагаа мандуулах эрхийг хүлээн зөвшөөрсөн Барселоны 1921 оны тунхаглал	1976.10.15
2	"Далайн эрх зүйн тухай" НҮБ-ын Конвенци-1982	1996.05.28
3	"Олон Улсын Далайн Байгууллагын тухай" Олон Улсын Конвенци, 1948	1996.05.28
4	"Хөлөг онгоцны багтаамжийн хэмжилтийн тухай" Конвенци, 1969	2001.11.15
5	"Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай" Конвенци	2001.12.14
6	"Далайд хөлөг онгоцууд мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх Олон Улсын Дүрмийн тухай" Конвенци	2001.12.14
7	"Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай" Конвенци	2001.12.14
8	"Далайг хөлөг онгоцоос бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай" Конвенци	2001.12.14
9	"Даацын тэмдэглэгээний тухай" Конвенци	2002.10.11
10	"Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцоос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай" Конвенци, 1969	2002.10.11
11	"Далайн навигацын аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай" Конвенци	2005.08.04
12	"Далайн хиймэл дагуулын /сансрын/ хөдөлгөөнт холбооны Олон Улсын байгууллага байгуулах тухай" Конвенци	2011.06.09
13	"Хөлөг онгоцны шатахууны савны тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлээх иргэний хариуцлагын тухай" Конвенци	2011.06.09
14	"Хөлөг онгоцны тэнцвэржүүлэгч ус болон үлдэгдэл тунадасны хяналт ба менежментийн тухай" Конвенци	2011.06.09
15	"Далайн нэхэмжлэлийн талаар хүлээх хариуцлагыг хязгаарлах тухай" Конвенци, 1976	2011.06.09
16	"Далайн хөдөлмөрийн тухай" Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын тухай Конвенци	2014.11.21
17	"Аврах ажиллагааны тухай" Конвенци	2014.11.21
18	"Далайн навигацын аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай" Конвенцийн 1988 оны Протокол	2005.08.04
19	"Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцоос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай" Олон Улсын Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулсан 1992 оны Протокол	2006.06.09
20	"Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай" Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1988 оны Протокол	2007.05.04
21	"Даацын тэмдэглэгээний тухай" Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1988 оны Протокол	2007.05.04
22	"Далайг хөлөг онгоцны бохирдлоос сэргийлэх тухай" Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1997 оны протокол (Хавсралт 6)	2007.05.04
23	"Олон Улсын Далайн Байгууллагын тухай" Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1991 оны Протокол	2007.05.04
24	"Олон улсын Далайн Байгууллагын тухай" Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1993 оны Протокол	2008.08.17
25	"Далайн нэхэмжлэлийн талаар хүлээх хариуцлагыг хязгаарлах тухай" Конвенцийн 1996 оны Протокол	2011.06.09



Оросын Холбооны Улстай “Монгол Улс ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон далайд гарах тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 1992 онд байгуулсан. Хэлэлцээрийн дагуу ОХУ-ын Алс Дорнодын далайн боомтуудаар далайд гарах нөхцөл баталгаажсан.



“Монгол Улс, Хятад Улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай” хоёр улсын Засгийн газар хооронд 2014 онд шинэчлэн байгуулсан хэлэлцээрээр БНХАУ-ын Хойд болон Зүүн хойд бүс нутгийн гадаад худалдаанд нээлттэй далайн боомтуудаар дамжин Монгол Улс далайд гарах нөхцөл эрх зүйн хувьд нээлттэй болсон.






**Хэлэлцээрийн үр дүнд:**


Монгол Улсын ашиглах нэр заасан далайн боомтын тоог нэмэгдүүлж Хятадын Хойд бүс нутаг болон Зүүн Хойд Хятадын бүс нутгийн гадаад худалдаанд нээлттэй нийт 7 боомтыг ашиглахаар тохиролцов.



## IV. ДАЛАЙН ЭРХ ЗҮЙН ТУХАЙ КОНВЕНЦ


Далайн эрх зүйн тухай конвенцийг 1982 онд НҮБ-аас батлан гаргасан.



-  Талууд
-  Нэгдэж орсон Европын холбооны улсууд
-  Зөвшөөрч гарын үсэг зурсан улсууд
-  Нэгдэж ороогүй улсууд



## “ДАЛАЙН ЭРХ ЗҮЙН ТУХАЙ” КОНВЕНЦООР ЗӨВШИЛЦСӨН ДАЛАЙН ХИЛ ХЯЗГААР



“ИХ ДАЛАЙ”

“Эдийн засгийн онцгой бүс”

Эргээс 200 миль буюу **322** км дотор талбайг

“Харьяа тэнгис”

12 миль  $\approx$  **19** км

“Дотоодын ус”

# ДАЛАЙН ЭРХ ЗҮЙН ТУХАЙ КОНВЕНЦ

87 дугаар зүйл.

## Их далайн чөлөөт байдал

1. Их далай нь эргийн улс, далайд гарцгүй улсуудыг оролцуулан бүх улсад нээлттэй байна. Их далайд чөлөөтэй зорчих явдлыг энэхүү Конвенц болон олон улсын эрх зүйн бусад хэм хэмжээгээр тодорхойлсон нөхцлийн дагуу хэрэгжүүлнэ. Үүнд эрэг бүхий болон далайд гарцгүй улсуудад адил хамаарах дор дурьдсан зүйлүүд орно. Үүнд:

- a) хөлөг онгоцоор чөлөөтэй зорчих
- b) чөлөөтэй нисэх
- c) 6 дугаар бүлгийг баримтлан усан доогуур кабел утас, дамжуулах хоолой чөлөөтэй тавих
- d) 6 дугаар бүлгийг баримтлан олон улсын эрх зүйгээр зөвшөөрөгдсөн хиймэл арал, бусад тоног төхөөрөмжийг чөлөөтэй барьж байгуулах
- e) 2 дугаар хэсэгт заасан нөхцлүүдийг баримтлан чөлөөтэй загас агнах
- f) 6 дугаар, 13 дугаар бүлгийг баримтлан шинжилгээ, судалгаа чөлөөтэй хийх

2. Их далайд чөлөөтэй зорчих эрхээ эдэлж байгаа бусад улсын эрх ашиг, түүнчлэн Район дахь үйл ажиллагааны талаар энэхүү Конвенцид заасан эрхийг зохих ёсоор харгалзан үзсэний үндсэн дээр бүх улс эдгээр эрх чөлөөг эдэлнэ.

## 89 дүгээр зүйл.

**Их далайд бүрэн эрхт байдал тогтоох оролдлогын хууль бус болох нь**  
Ямар ч улс их далайн аль ч хэсгийг өөрийн бүрэн эрхэд оруулан захирах эрхгүй.

## 90 дүгээр зүйл.

### **Хөлөг онгоцоор зорчих эрх**

Эрэг бүхий буюу далайд гарцгүй эсэхийг үл харгалзан улс бүр өөрийн далбаатай хөлөг онгоцоор их далайд зорчих эрхтэй.



2003-2018 он хүртэл

30 орчим улсын

3000 гаруй хөлөг  
онгоц


/Даац/  
9,971,190.62 тонн

Одоогийн байдлаар

380 хөлөг онгоц

/Даац/  
2,096,931.34 тонн

Дундаж наслалт 1993



**Тайлбар:** Монголын далбаатай хөлөг онгоцыг эзэмшигч улсын харьяаллаар харуулсан байдал (2016 оны байдлаар).

## 10 ДУГААР БҮЛЭГ.

### ДАЛАЙД ГАРЦГҮЙ УЛСУУДЫН ДАЛАЙД ГАРАХ, ТҮҮНЭЭС БУЦАЖ ГАРАХ, ЧӨЛӨӨТЭЙ ДАМЖИН ӨНГӨРӨХ ЭРХ

124 дүгээр зүйл.

#### Нэр томъёог хэрэглэх

Энэ Конвенцийн зорилгод:

- a) \далайд гарцгүй улс\ гэж далайн эрэггүй улсыг хэлнэ
  - b) \дамжуулан өнгөрүүлэх улс\ гэж нутаг дэвсгэрээрээ дамжин өнгөрөх хөдөлгөөнийг нэвтрүүлж байгаа бөгөөд далайд гарцгүй улс болон далайн хооронд байршилтай далайн эрэг бүхий буюу далайн эрэгтэй улсыг хэлнэ.
  - c) \дамжин өнгөрөх хөдөлгөөн\ гэж нэг буюу хэд хэдэн дамжин өнгөрүүлэгч улсын нутаг дэвсгэрээр хүмүүс, ачаа, бараа, тээврийн хэрэгсэл, дамжин өнгөрөхийг хэлнэ. Ачааг буулгах, ачих, хадгалах, ачааг ялгаж хуваах, тээврийн хэрэгсэлийг солихыг оруулан эсвэл эдгээргүйгээр дээрх нутаг дэвсгэрээр нэвтрэн өнгөрөх нь далайд гарцгүй улсын нутаг дэвсгэрээс эхлэх буюу тэнд дуусах нэгэн бүтэн замын зөвхөн бүрэлдэхүүн хэсэг байх болно.
  - d) \тээврийн хэрэгсэл \ гэж:
    - I) Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, далай, нуур, голын хөлөг онгоцууд, автомашины тээвэр
    - II) Орон нутгийн нөхцөлд шаардлагатай зөөгч, ердийн хөсгийг тус тус хэлнэ.
2. Далайд гарцгүй улс, дамжуулан өнгөрүүлэгч улс өөр хоорондоо хэлэлцэн тохирч, тээврийн хэрэгслийн тоонд дамжуулах хоолой, хий дамжуулах хоолой 1-д зааснаас бусад тээврийн хэрэгслийг оруулж болно.

## 125 дугаар зүйл.

### **Далайд гарах, түүнээс буцаж гарах болон чөлөөтэй дамжин өнгөрөх эрх**

1. Далайд гарцгүй улсууд энэхүү Конвенцид заасан эрх, түүний дотор их далайд чөлөөтэй зорчих, хүн төрөлхтний нийтийн өвтэй холбоотой эрхийг эдэлнэ. Энэ зорилгоор далайд гарцгүй улс дамжин өнгөрүүлэгч улсын нутаг дэвсгэрээр тээврийн бүх төрлийн хэрэгслээр чөлөөтэй дамжин өнгөрнө.
2. Холбогдох далайд гарцгүй улс, дамжин өнгөрүүлэгч улс чөлөөтэй дамжин өнгөрөх нөхцөл, журмыг хоёр талт, салбар бүс нутгийн буюу бүс нутгийн гэрээ хэлэлцээр байгуулах журмаар хоорондоо тохирч байна.

## 127 дугаар зүйл.

### **Гаалийн татвар, татвар болон бусад хураамж**

1. Ийм хөдөлгөөнтэй холбогдуулан тусгай үйлчилгээ үзүүлсний хураамж авахаас бусад тохиолдолд дамжин өнгөрөх хөдөлгөөнөөс ямар нэгэн гаалийн татвар, татвар бусад хураамж авахгүй.
2. Дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгсэл, далайд гарцгүй улсад олгосон, түүний ашиглаж байгаа бусад хэрэгслээс дамжуулан өнгөрүүлэгч улсын тээврийн хэрэгсэлд ноогдуулдгаас илүү татвар буюу хураамж авч болохгүй.

## 128 дугаар зүйл.

### **Чөлөөт бүс, гаалийн бусад хөнгөлөлт**

Дамжин өнгөрөх хөдөлгөөнийг хөнгөвчлөх зорилгоор далайд гарцгүй улс, дамжин өнгөрүүлэгч улсууд хоорондоо хэлэлцэн тохирох замаар дамжин өнгөрүүлэгч улсад орох, гарах боомтод татваргүй бүс, гаалийн бусад хөнгөлөлт тогтоож болно.

## 130 дугаар зүйл.

### **Дамжин өнгөрөх хөдөлгөөний үед техникийн чанартай саатал, бусад бэрхшээл гаргуулахгүй байх буюу тэдгээрийг арилгах арга хэмжээ.**

1. Дамжин өнгөрөх хөдөлгөөны үед техникийн саатал, бусад бэрхшээл гаргуулахгүй байх буюу тэдгээрийг арилгах бүхий л зохистой арга хэмжээг дамжин өнгөрүүлэгч улс авч байна.
2. Ийм саатал бэрхшээл тохиолдох үед түүнийг түргэн арилгах зорилгоор дамжин өнгөрүүлэгч улс, холбогдох далайд гарцгүй улсын эрх бүхий байгууллагууд хамтран ажиллана.

## V. ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХУДАЛДАА ХӨНГӨВЧЛӨХ ХЭЛЭЛЦЭЭР

Дэлхийн худалдааны байгууллагаас Худалдаа хөнгөвчлөх хэлэлцээрийн протоколыг шинээр боловсруулан 2014 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр эцэслэн боловсруулж гишүүн орнуудыг нэгдэж орохыг уриалсан.

- 2017 оны 2 дугаар 22-ны өдрөөс ДХБ-ны гишүүн орнуудын 3/2 хувь хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болсон.
- Одоогийн байдлаар 122 Улс протоколд тусгагдсан нөхцлийг хүлээн зөвшөөрч нэгдэж ороод байгаагаас
  - БНХАУ 2015.09.04
  - ОХУ 2016.04.22
  - Монгол Улс 2016.11.28

тус хэлэлцээрт нэгдэж орсон.




# ХЭЛЭЛЦЭЭРИЙН АЧ ХОЛБОГДОЛ

- Бараа бүтээгдэхүүнийг хилээр гаргахад учирдаг гаалийн болон бусад төрийн байгууллагын шат дамжлага, олон төрлийн баримт бичгийн бүрдүүлэлтээс шалтгаалан гардаг хүнд суртлыг бууруулах талаар заалтууд орсон. Худалдааг хөнгөвчлөхөд дараахь ойлголтууд орох бөгөөд үүнд:
  - Худалдааг хялбаршуулахад нөлөөлөх орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх,
  - Худалдааны үйл ажиллагааг түргэн шуурхай болгох,
  - Ил тод, үр ашигтай байлгах
  - Дүрэм журмыг багасгаж экспорт импортын бараа бүтээгдэхүүний шат дамжлагыг түргэн шуурхай болгоход шаардагдах нэгдсэн бодлого боловсруулах гэх мэт асуудлаар дэлхийн худалдааны нэгдсэн системийн хүрээнд хамтран ажиллахад оршино.
- ХХХ-т транзитаар дамжин өнгөрч буй бараа бүтээгдэхүүний гаалийн үзлэг хяналтыг түргэн шуурхай гүйцэтгэх заалтуудыг тусгаж өгсөн байна. Мөн энэхүү үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, техникийн тусламж үзүүлэх талаар тусгагдсан байна.



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ



ДАЛАЙН ЗАХИРГАА

# Анхаарал хандуулсан таньд баярлалаа

*Холбоо барих:*

*Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж –11, Засгийн газрын XI байр, 603, 604, 611, 612 тоот.*

*Утас: 261488, 261489, 261490, 70114801*

*Факс: 11-310642*

*Цахим хуудас: [www.monmarad.gov.mn](http://www.monmarad.gov.mn)*

*[www.facebook.com/monmarad](https://www.facebook.com/monmarad)*

*[www.twitter.com/monmarad](https://www.twitter.com/monmarad)*

*Цахим хаяг: [info@monmarad.gov.mn](mailto:info@monmarad.gov.mn)*